

Засгийн газрын 2018 оны ... дугаар сарын ....-ны  
өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

## “МАЛЫН ЭМИЙН ҮЛДЭГДЛИЙГ ХЯНАХ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д хүнсний үйлдвэрлэл, боловсруулалт, борлуулалтын бүх үе шатанд хүнсний аюулгүй байдал, чанар, эрүүл ахуй, ариун цэврийн зохистой орчин бүрдүүлж, хүн амыг аюулгүй хүнс тэжээлээр хангах, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилтуудыг дэвшүүлсэн.

Монгол Улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд Эрүүл ахуй, ургамал хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (“SPS”), Худалдаан дахь техникийн саад тоггорын тухай Хэлэлцээр (“ТВТ”), Кодекс Алиментариус –ийн зөвлөмж (“САС”) зэрэг олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүнсний аюулгүй байдалтай холбоотой заалтуудад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх үүрэг хүлээсэн билээ.

Улс орнуудын хөгжлийнхөө түвшингөөс үл хамааран хүнсний бүтээгдэхүүний чанараас гадна аюулгүйн баталгаат байдал, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй мал эмнэлгийн эм болон мал эмнэлэгт хэрэглэж байгаа химийн элдэв бодисын үлдэгдэлгүй байхыг ихээхэн анхаарч байна. Энэ ойлголтын салшгүй нэг хэсэг нь хүнсний зориулалттай малын бие болон тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн дэх эмийн үлдэгдлийг хянах асуудал юм.

Манай улсын хувьд мал эмнэлгийн байгууллагуудын лабораториуд, нэн ялангуяа эмийн болон хорын судалгаа, шинжилгээний лабораторийн сорилт, баталгаажуулалтын чадавхи сул байгаа нь эмийн үлдэгдлийн илрэл, хор холбогдлыг бодитоор үнэлэх, улмаар эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга зүйн орчин бүрдэхгүй байна.

Манай орны хувьд 3 сая гаруй хүн амтай, малын тоо 61.5 саяд хүрээд байгаа ба малын гаралтай бүтээгдэхүүн, ялангуяа мах, сүүг хоол хүнсэндээ түлхүү хэрэглэдэг онцлогтой. Сүүлийн жилүүдэд тахиа, далайн гаралтай бүтээгдэхүүн болон гахайны махыг импортоор авч өргөнөөр хэрэглэж байна. Өнөөдөр мал аж ахуйн практикт 800 гаруй эмийг улсын бүртгэлд бүртгэн хэрэглэж байгаа ба хүнсэнд хэрэглэж буй мал, түүнээс авах бүтээгдэхүүнийг тухай бүр лабораторийн шинжилгээнд хамруулан дүгнэлт гаргах, эмийн зохисгүй хэрэглээний эрсдлээс сэрэмжлүүлэх тогтолцоо үйлчлэхгүй байна.

Түүнчлэн, малын эмч нарын эмийн жор бичилт хангалтгүй, эмийн сангууд зөвхөн ашиг хөөн эмийг жоргүй олгох үзэгдэл түгээмэл, жороор эм олголтод тавих хяналт хангалтгүй байна. Малчид, мал бүхий иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээний ойлголт, хандлага төлөвшөөгүйгээс төрөл бүрийн эм, бэлдмэлүүдийг өөрсдийн дураар зах зээлээс авч, замбараагүй хэрэглэдэг буруу дадал байсаар байна.

Тухайлбал малд хэрэглэсэн эмийн бодис малын биеэс бүрэн гадагшлаагүй байхад нь хүнсэнд хэрэглэснээс тухайн эмийн үлдэгдэл хүнсний бүтээгдэхүүнээр дамжин хүний эрүүл мэндэд хохирол учруулах томоохон эрсдэл байсаар байна. Хүнд харшил, бэлгийн сулрал, хордлого үүсгэх, удамшилд нөлөөлөх ба тератогений үйлчилгээ үзүүлэх, эмэнд дасал болох, хавдар үүсэх зэрэг сөрөг нөлөө бий болж байна.

Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажлын хүрээнд цаашид эмийг (антибиотик, гормон зэрэг) зөв сонгох, бүртгэлийн тогтолцоог шинэчлэх, жороор олгох журмыг мөрдөх, мал эмнэлгийн байгууллагуудад эмийн хор уршигаас сэргийлэх, хянах байнгын тогтолцоо бий болгох, иргэд, малчдын мэдлэг, хандлагыг дээшлүүлэх зэрэг тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймээс мал эмнэлэгт үлдэгдэл өгдөг эм хэрэглэхээс татгалзах, малын эмийн үлдэгдлийг илрүүлэх, үнэлэх, хянах сэрэмжлүүлгийн тогтолцоо үүсгэн, салбарын бэлэн байдал, хариу арга хэмжээг төлөвшүүлэх, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Малын эмийн үлдэгдлийг хянах үндэсний хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг боловсруулав.

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа**

### **2.1. Хөтөлбөрийн зорилго**

Мал эмнэлгийг эмчилгээний өвөрмөц идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай, сонголт хийх боломж бүхий эмээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн үлдэгдлийн байнгын илрүүлэлт, судалгаа, үнэлгээ, хариу арга хэмжээг авах тогтолцоо бүрдүүлж, улмаар эмийн зохистой хэрэглээгээр дамжуулан хүний эрүүл мэндийг хамгаалж, хүнсний аюулгүй байдлыг хангахад оршино.

### **2.2. Хөтөлбөрийн зорилт**

Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

2.2.1. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

2.2.2. Эмийн зохистой хэрэглээ төлөвшүүлж, эмчилгээний идэвхитэй, чанартай, аюулгүй эмээр хангана.

2.2.3. Мал эмнэлгийн эм зүйн салбарын мэргэшсэн, ур чадвар бүхий хүний нөөцөөр хангана.

2.2.4. Малыг эм, химийн бодисын үлдэгдлийг хянах судалгаа, шинжилгээний лабораторийг улс, орон нутгийн түвшинд бэхжүүлнэ;

2.2.5. Мал, амьтны эмийн мэдээллийн сүлжээг бий болгон, олон нийтэд нээлттэй болгох орчинг бүрдүүлнэ.

2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа: Хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлнэ.

## **Гурав. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

### *3.1. Хөтөлбөрийн 2.2.1 дэх зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:*

3.1.1. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний чанарын болон эмийн сангийн үйл ажиллагааны стандартуудыг шинэчлэн боловсруулах;

3.1.2. Мал, амьтны эмийн импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтад мөрдөж буй дүрэм, журам, заавар, жагсаалтыг шинэчлэх;

3.1.3. Улсын болон орон нутгийн мал эмнэлгийн байгууллагын лабораториудад мөрдөж буй журам, зааврыг шинэчлэх;

3.1.4. Эмийн үлдэгдлийг илрүүлэх лабораторийн шинжилгээний нийтлэг аргачлалууд бүхий фармакопейн өгүүллүүдийг боловсруулах, батлан мөрдөх.

### *3.2. Хөтөлбөрийн 2.2.2 дахь зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:*

3.2.1. Малыг гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд эмийн үлдэгдэл тодорхойлох ажлыг үе шаттайгаар гүйцэтгэх;

3.2.2. Мал эмнэлгийн эмийн сан, шинжилгээ, баталгаажуулалтын лабораториудад олон улсын болон үндэсний стандартуудыг нэвтрүүлэх, мөрдүүлэх;

3.2.3. Мал, амьтны өвчин үүсгэгч нянгуудын мал эмнэлэгт хэрэглэж байгаа антибиотикүүдэд үзүүлэх тэсвэрт чанарыг илрүүлэх, үнэлэх шинжилгээг жил бүр тогтмол хийх;

3.2.4. Эмийн бүртгэлд “тооноос чанарт” зарчим хэрэгжүүлж, мал, амьтны эмийг жороор олгох тогтолцоонд шилжих.

3.3. Хөтөлбөрийн 2.2.3 дахь зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.3.1. Аймаг, сум, аж ахуйн нэгжийн захиалгаар эм зүйн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, төгсөлтийн дараах болон мэргэшүүлэх, давтан сургалтыг эм зүйн гүнзгийрүүлсэн түвшинд, лабораторийн орчинд зохион байгуулах;

3.3.2. Малчид, мал бүхий иргэд, махны үйлдвэрийн болон хүнсний захын ажилчдын малын эм, эмийн үлдэгдэл, түүнээс сэргийлэх, сэрэмжлүүлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх;

3.3.3. Мал эмнэлгийн эмийн салбарт ажиллах боловсон хүчинд мэргэшлийн ур чадвар олгох сургалтыг олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр шийдвэрлэх;

3.3.4. Мал эмнэлгийн эм зүй, фармакогнози, эмийн технологи, эмийн маркетинг болон эмийн эдийн засгийн сурах бичгүүдийг зохиох, хэвлэх, нийтийн хүртээл болгох.

3.4. Хөтөлбөрийн 2.2.4 дэх зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.4.1. Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдэд /мах, сүү, зөгийн бал, ургамлын бүтээгдэхүүн гэх мэт/ эмийн үлдэгдэл бодис тодорхойлох лаборатори байгуулах;

3.4.2. Мал эмнэлгийн эмийн салбарын судалгаа ба боловсруулалтын тэргүүлэх чиглэлийг тогтоож, инновацийн орчин бүрдүүлэх;

3.4.3. Малын эмийн чанарын болон мал эмнэлгийн эмийн үйлдвэрүүдийн хяналтын лабораториудыг үндэсний болон олон улс, бүс нутгийн итгэмжлэлд хамруулах;

3.4.4. Аймаг, сумын түвшинд эмийн гаж нөлөө илрүүлэх, үнэлэх, сэрэмжлүүлэх, эргүүлэн татах мэргэжлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

3.4.5. Эм, эмийн болон химийн бодисын хаягдалын менежментийг төлөвшүүлэх замаар хүн, байгаль орчинд нөлөөлөх мал эмнэлгийн эмийн сөрөг үйлчилгээг бууруулах.

3.5. Хөтөлбөрийн 2.2.5 дэх зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.5.1. Мал эмнэлгийн эмийн бүртгэл, эмийн чанарын баталгаажуулалт, эм хангамжийн байгууллагын нэгдсэн цахим бүртгэлийн тогтолцоог хөгжүүлэх;

3.5.2. Нянгийн тэсвэржилтийн тандалтын олон улсын сүлжээнд мал эмнэлгийн лабораториудыг хамруулж, мэдээлэл солилцох;

3.5.3. Гаалийн болон хяналтын байгууллагын мэдээ, тайланд үндэслэн мал эмнэлгийн эмийн хэрэглээг зохицуулах;

3.5.4. Мал, амьтны өвчний гаралт, тархалт, эрсдэлтэй уялдуулан шинээр бүртгэх болон шинээр хэрэглээнд нэвтрүүлэх эмийн сонголтыг хийх.

**Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт**

**4.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

4.1.1. хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ 2018 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг явц болон үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

**4.1.2. явцын үзүүлэлт:**

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэм-жих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Мэдээллийн эх сурвалж	Хэрэгжүүлэх Байгууллагууд
				Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт		

1	2.2.1. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	Стандартууд шинэчлэгдэн батлагдсан байна.						МЭЕГ, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, Фармакопейн хороо, Эмийн зөвлөл, эмийн үйлдвэрүүд, Эм ханган нийлүүлэх байгууллагууд.
		Шинэ дүрэм, заавар, журам, жагсаалт батлагдсан байна.						
		Шинэчлэгдсэн журам, заавар.						
		Нийтлэг аргачлалууд бүхий фармакопейн өгүүллүүд						
2	2.2.2. Эмийн зохистой хэрэглээ төлөвшүүлж, эмчилгээний идэвхитэй, чанартай, аюулгүй эмээр хангана.	Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд эмийн үлдэгдэл тодорхойлох ажил хийгдсэн байна.						
		Олон улсын болон үндэсний стандартуудыг нэвтрүүлсэн байна.						
		Антибиотикуудад үзүүлэх тэсвэрт чанарыг илрүүлэх, үнэлэх шинжилгээг жил бүр хийгдэнэ.						
		Мал, амьтны эмийг жороор олгодог болно.						
3	2.2.3. Мал эмнэлгийн эм зүйн салбарын мэргэшсэн, ур чадвар бүхий хүний нөөцөөр хангана.	Эм зүйн гүнзгийрүүлсэн түвшиний лабораторийн сургалт зохион байгуулсан байна.						
		Малын эм, эмийн үлдэгдэл, түүнээс сэргийлэх, сэрэмжлүүлэх талаарх мэдлэгийг дээшилсэн байна.						
		Мэргэшлийн ур чадвар олгох сургалтад						

		оролцсон байна.							
		Сурах бичгүүдийг нийтийн хүртээл болгосон байна.							
4	2.2.4. Малын эм, химийн бодисын үлдэгдлийг хянах судалгаа, шинжилгээний лабораторийг улс, орон нутгийн түвшинд бэхжүүлнэ	Эмийн үлдэгдэл бодис тодорхойлох лаборатори байгуулагдсан байна.							
		Судалгаа ба боловсруулалтын тэргүүлэх чиглэл бий болно.							
		Лабораториудыг итгэмжлэлд хамруулсан байна.							
		Эмийн гаж нөлөө илрүүлэх, үнэлэх, сэрэмжлүүлэх, эргүүлэн татах үйл ажиллагаа тогтворжсон байна.							
		Мал эмнэлгийн эмийн сөрөг үйлчилгээг бууруулсан байна.							
	2.2.5. Мал, амьтны эмийн мэдээллийн сүлжээг бий болгон, олон нийтэд нээлттэй болгох орчинг бүрдүүлнэ	1. Нэгдсэн цахим бүртгэлийн тогтолцоотой болсон байна.							
		2. Нянгийн тэсвэржилтийн тандалтын олон улсын сүлжээнд нэгдсэн байна.							
		3. Мал эмнэлгийн эмийн хэрэглээ зохицуулалттай болсон байна.							
		4. Эмийн сонголтын шинэ тогтолцоо бүрдсэн байна.							

## **Тав. Шаардагдах хөрөнгийн хэмжээ,эх үүсвэр,хэрэгжих хугацаа**

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улсын төсөв, олон улсын байгууллага, гадаад орны зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.2. гоц халдварт, халдварт, зооноз өвчин дэгдсэн онцгой байдлын үед улсын болон орон нутгийн төсөв;

5.1.3. төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.1.4. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

## **Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ,үнэлгээ**

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг жил бүр хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран жил бүр гүйцэтгэнэ.

6.2. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналт, мал эмнэлгийн байгууллагатай хамтран гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийж Засгийн газарт танилцуулна.

6.4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа үр дүнгийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулна.

6.5. Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.6. Үр дүнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж нь холбогдох бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл болно.

## **Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

7.1. Хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, харьяа агентлаг, мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

7.2. Хөтөлбөрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд удирдан зохион байгуулах, зохицуулах үүргийг Засаг дарга, хэрэгжүүлэх ажлыг тухайн орон нутгийн мэргэжлийн байгууллага;